

ТЕРРОРИЗМЫН ЭСРЭГ ХИЙХ ТЭМЦЭЛД БУУ ЮУ ЭСВЭЛ ҮЗЭЛ СУРТАЛ УУ

Э.Эрдэнэ*

Орчин үед “терроризмтэй тэмцэх” явдал нь арга, хэрэгсэлтэй тэмцэх бус, тодорхой үзэл санаа, номлолд тулгуурласан “үзэл суртал”-тай тэмцэх асуудал болжээ. Өөрөөр хэлбэл терроризмтэй тэмцэх чиглэлээр авч ирсэн арга хэмжээнүүдийн үр дүнд террорист байгууллагуудын санхүүжилтийг хязгаарлах, халдлага хийх боломжийг бууруулах, дайчид бэлтгэх баазуудыг үгүй хийх зэрэг ажиллагаанууд явагдаж тодорхой үр дүнд хүрсэн боловч үүний нөгөө талд лалын дайчид өдөр ирэх тусам нэмэгдэж, террорист үйл ажиллагаа цар хүрээгээ тэлсээр ирсэн. Учир нь дэлхийн нийт хүн амын 19.2 хувийг эзэлж байгаа¹ мусульманчуудын өдөр тутмын амьдран буй нийгэмд тэдний шашин, соёлд тулгуурлан лалын радикал үзлийг номлогчид санхүүгийн өргөн дэмжлэгтэйгээр үзэл суртал, номлолоо чөлөөтэй явуулж, “лал”²-ын радикал³ үзэлтнүүдийг бэлтгэсээр байна. Энэ нөхцөл байдлыг бүрэн тооцоолж, авах арга хэмжээгээ боловсруулж чадаагүй учраас дэлхийн орнууд терроризмтэй тэмцэх чиглэлд төдийлөн амжилтанд хүрээгүй болно.⁴ Иймд терроризмтай тэмцэх чиглэлд юуны түрүүнд улс төрийн хүчирхийлэл, лалын радикализмыг төрүүлж буй үзэл суртлын мөн чанар, түүнийг түгээн дэлгэрүүлэгчдийн талаар нарийвчилсан судалгаа хийх, судалгаанд үндэслэн тус үзэл суртлыг номлогч, дэлгэрүүлэгч байгууллага, хувь хүний эсрэг авах арга хэмжээг төлөвлөх шаардлагатай байна.

Лалын радикализмыг номлогчид ба дэмжигчид

Эртнээс Коран судрын үндсэн үзэл санаанд хүчирхийллийг урьтал болгож байсан уламжлал байхгүй. Дайны цагийн номлол болон энх цагийн номлол нь хослон оршиж ариун дайны үзэл санаагаар хамгийн сүүлд хүчирхийлэл хэрэглэхийг зөвшөөрч байсан. Гэтэл 19-20 дугаар зууны үед олон тооны лалын шашинтай орнууд өрнөдийн колони болж үүний зэрэгцээ боловсрол ч доод цэгтээ тултал унасан. Харин эдгээр орнуудад эрх чөлөөний төлөө тэмцэгч мусульманчууд колоничлогчдын эсрэг тэмцэх үзэл суртлын үндсийг бүрдүүлэхдээ Коран болон Суннийн судруудыг зөвхөн цэрэг, дайны үзэл санаагаар тайлбарлах

* Э.Эрдэнэ - МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант

болсон ба үүнийг нь тухайн үед шашны боловсрол дорой хүмүүс гарцаагүй зөв тайлбар хэмээн хүлээн авсан байдаг. Түүгээр ч зогсохгүй зарим бүс нутагт дээрх хэлбэрээр номлол үйлдэх нь заншил болж хувирсан байна.

Орчин үеийн лалын радикал үзэлтнүүдийн анхны хөдөлгөөн 1928 онд “Мусульман ахан дүүс” гэх байгууллага бий болсноор үүссэн гэж үздэг. Лалын радикал үзэл суртлын үндсийг 13 дугаар зууны их сэтгэгч Ибн-Тамий үндэслэсэн бол 18 дугаар зуунд түүний номлолыг залгамжлагчаар Муххамед Абдул Ваххаб тодорч үйл хэргийг нь үргэлжлүүлсэн юм. Дээр дурдсан сэтгэгчид болон тус хөдөлгөөний гол сэтгэгч болох Саид Кутб нар лалын уналтыг зөвхөн “жинхэнэ” итгэгчид гэгээн элч Муххамедын аргаар оршин буй лалын орнуудыг нэгтгэхийн төлөө тэмцэж эхэлснээр зогсоож чадна гэж үздэг байжээ.

“Мусульман ахан дүүс” байгууллагаас олон тооны үзэл суртлын номлогч байгууллагууд салбарлан үүссэний дотроос хамгийн том нь 1953 онд байгуулагдсан “Хизб ут-Тахрир”⁵ (ХТ) юм. Тус байгууллагыг Палестины шүүгч Такиуддин аль-Набхани үндэслэсэн бөгөөд тэрээр Кутб болон бусад шашны сэтгэгчдийн номлолд тулгуурлан өөрийн номлолыг боловсруулжээ. Түүний үзлээр “Капитализм бол дарангуйлагчдын тогтолцоо, ардчилал бол бурхангүй дэглэм” бөгөөд гэгээн элч Муххамедын номлосны дагуу лалын ертөнцийг эргүүлэн сэргээхийн тулд мусульманчуудыг “буруу номтнууд”-ын үзэл санаа, тогтолцоо, хууль журмаас ангижруулах, шинэ халифатын дор бүх мусульманчуудыг нэгтгэх хэрэгтэй гэжээ.

Мөн тэрээр өрнөдийн иргэншил бол мусульманчуудын ертөнцөд сэтгэлгээний ноёрхлыг тогтоохоор эрмэлзэж буй лалын ертөнцтэй харилцан хамааралгүй тогтолцоо гэж үзэж байсан ба капитализм, социализмын аль алиныг нь тэрслүү үзэлд тооцдог байв. Тиймээс ч тэд социалист колоний системийг нуран унах үйл явцыг маш их сэтгэл хөдлөлтэйгөөр хүлээн авч, капитализмыг ХТ-ын өмнө үлдсэн цорын ганц дайснаа гэж зарлан тунхагласан.⁶ Түүнчлэн ХТ нь одоогийн лалын шашинт орнуудын удирдлагыг үгүйсгэдэг ба тэдний хувьд “терроризмтай тэмцэх” гэдэг нь “лалын шашинтай дайтах” гэсэнтэй агаар нэг ажээ. ХТ-ын үзэл суртлыг “Аль-Каида”,⁷ “Хезболла”,⁸ “Хамас”⁹ зэрэг террорист байгууллагууд үйл ажиллагааны үндэс болгодог.

Набханы үхлийн дараа палестиний Абдул Кадим Заллум 1997 онд түүний орыг залгасан бол 2003 онд түүний дараагийн залгамжлагчаар Иордан дахь ХТ-ын хэвлэлийн төлөөлөгч асан

Ата Абу Эль-Рашта тодорсон байна. Эль Раштагийн үеэс ХТ нь илүү идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба өрнөдийн тусгай албадын мэдээгээр ХТ нь АНУ болон түүнийг дагалдан баясагчид “түүн дотроо Ирак дахь АНУ-ын цэрэг, дайны үйл ажиллагааг дэмжсэн орнууд”-ын эсрэг үйл ажиллагаа явуулах даалгаврыг гишүүддээ өгсөн байна.

ХТ-аас салбарлан гарсан дараах байгууллагууд байдаг. Үүнд:

1. “Палестиний исламын жихад”-1958 онд Шейх Ассад Байюд Тамими үүсгэн байгуулсан.
2. “Аль-Мухажирун”-1996 онд Омар Бакри Муххамед үүсгэн байгуулсан. /Албан ёсоор татан буугдсан гэх боловч нууцаар үйл ажиллагаа явуулдаг/
3. “Акрамийя”-1996 онд Узбекистанд байгуулагдсан.
4. “Хизб ун-Нусра” - 1999 онд Узбекистаны Ташкент хотод байгуулагдсан.

ХТ нь өөрийгөө улс төрийн нам гэж үздэг боловч хаана ч, хэзээ ч бүртгэгдэж байгаагүй, өөрийн төлөөлөгчдийг улс төрийн аливаа сонгуульд нэр дэвшүүлдэггүй. Түүнчилэн чөлөөтэй үйл ажиллагаа явуулах зорилгоор өөрийнхөө гишүүдийг гэмт хэрэг болон аливаа террорист үйл ажиллагаанд оролцохыг хатуу хориглодог онцлогтой. Тэд өөрийн “утопи” бодлогыг үзэл суртлын тэмцлийн аргаар хэрэгжүүлэхийг зорьдог ба үүндээ дэлхий дахинд тархсан намын нууц салбар, үүрийг ашигладаг байна.

ХТ нь фашистуудын уран илтгэл, ленинч стратеги, өрнөдийн зар сурталчилгааны арга, ваххабист¹⁰ номлолын арга зүй зэргийг чадварлаг ашигладаг ба либерал ертөнцөд тэмцэхэд бэрх өрсөлдөгч юм.

“Хизб ут-Тахрир” дэлхий дахинд

ХТ-ын номлол, явуулж буй үйл ажиллагаа, түүхэн замнал зэргээс харахад ХТ нь хүчирхийллийг өөрөө үйлддэггүй, оюуны, үзэл суртлын байгууллага бөгөөд террористуудыг бэлтгэдэг үзэл суртлын сургууль юм.

ХТ-ын гол онцлог нь бусад фундаменталист,¹¹ радикал байгууллагуудтай харьцуулахад маш өргөн хүрээтэй асуудлуудад анхаарал хандуулдаг ба бусад урсгал, номлолуудтай огтхон ч зөрчилддөггүй. Тухайлбал дэлхий дахины мусульманчуудын хүний эрхийн асуудал, иргэншлүүдийн мөргөлдөөний асуудлуудыг авч үздэг бөгөөд байнгын маргаантай байдаг сунни, шийт урсгалуудыг ч үзэл суртлын “туган дор”-оо нэгтгэж чадсан байна.

“Никсоны Төв”-ийн хийсэн судалгаагаар ХТ нь шинэ халифатыг байгуулах зорилгодоо анхны лалын эзэнт гүрнийг байгуулсан гэгээн элч Муххамедын аргыг¹² хэрэглэдэг ба дараах үндсэн гурван зорилтыг дэвшүүлэн ажилладаг байна. Үүнд:

1. ХТ-ын үзэл суртлыг идэвхтэй дэлгэрүүлж, олон тооны гишүүд эслүүлэх замаар “Чөлөөлөх нам” байгуулах. /Технологийн дэвшил, орчин үеийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл нь ХТ-т энэ зорилтыг биелүүлэхэд өргөн боломж олгосон. Тухайлбал ХТ-ын веб сайтууд интернэтээр дамжуулан хэдэн сая гишүүнийг өөрийнхөө эгнээнд элсүүлдэг байна/

2. ХТ-ын агуу төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор гишүүн бүр суугаа орондоо намын үүр болон нууц салбаруудыг байгуулж ард иргэд болон суугаа орны төр засгийн хооронд үл ойлголцол бий болгох. /Энэ зорилгодоо ХТ олон оронд хүрсэн гэж үздэг/¹³

3. Ийнхүү хоёрдугаар шатанд лалын хувьсгал хийх үндсээ бүрдүүлж, өөрийн үзэл суртлыг дэмжигч хүрээг тухайн улсын удирдлагын түвшинд бий болгосноор ямар нэгэн хүчирхийлэл үйлдэлгүйгээр төрийн эргэлт хийх.

ХТ нь өнөөдөр дэлхийн 40 гаруй оронд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд тухайн улс бүрийн онцлогт тохирсон стратегийг сайтар судлан боловсруулж, түүнийхээ үндсэн дээр ажиллаж байна. Тухайлбал Ойрхи Дорнод, Төв Ази болон Өмнөд Азийн орнуудад төрийн эргэлт хийхийг зорьдог бол Өрнөдөд эдгээр орнуудад амьдарч буй нийт мусульманчуудыг “лалын туган дор нэгтгэх”, Өрнөдийн соёл, иргэншилд уусахаас урьдчилан сэргийлэх явдлыг гол зорилго болгодог байна.

ХТ нь Ойрхи Дорнодын бүс нутагт 60, 70-аад оны үед идэвхтэй үйл ажиллагаа явуулж Иордани, Египет, Сири, Тунис, Ирак зэрэг орнуудад төрийн эргэлт хийх оролдлого хийж байсан. Иордани улсын засаг захиргаа ХТ-ыг эхний үед хүлээн зөвшөөрч улс төрийн намын хэмжээнд авч үзэж байсан ба тус улсын парламентад ХТ-ын гишүүн Ахмад ад-Даур гэгч парламентын гишүүнээр сонгогдон ажиллаж байжээ. ХТ нь Иорданид 1968, 1969, 1977, 1993 онд төрийн эргэлт хийх оролдлого хийж байсан бөгөөд хамгийн сүүлд буюу 2004 онд тус улсад ХТ-ыг сэргээх зорилгоор үйл ажиллагаа явуулж байсан 26 хүнийг Иорданийн тусгай алба илрүүлж, ял эдлүүлсэн байна.

ХТ нь Садам Хуссейний диктатурын үед Ирак улсад үзэл суртлаа дэлгэрүүлэх ажилд төдийлөн амжилт олоогүй боловч 2003 онд Хуссейны засаглал нуран унасаны дараагаар идэвхтэй

үйл ажиллагаа явуулах боломжтой болсон. Тус улсад үүссэн нөхцөл байдал нь ХТ-т үйл ажиллагаагаа явуулах таатай боломжийг бүрдүүлсэн ба тэд Иракийн ард түмэнд “Оюун санаагаа нэгтгэж чадсан суннит, шийтийн ахан дүүс нь дэлхийн хамгийн хүчирхэг армийн эсрэг эр зоригтой, амжилттай зогсож чадсан ба өөрсдийн итгэл, сүсэг бишрэлийн үндсэн дээр эзлэн түрэмгийлэгчдийн зүрхэнд айдас, өвдөлтийг мэдрүүлж тэдний омог бардам занг мохоож чадлаа” зэргээр ухуулга хийдэг байна.

Бүгд Найрамдах Турк Улсад ХТ-ын гишүүд төдийлөн амжилтанд хүрээгүй. 1967 онд тус улсын тусгай албад ХТ-ын Туркэд үндэс сууриа тавих анхны оролдлогыг таслан зогсоосон ба 2003 онд Турк дэх ХТ-ын салбарын дарга Амира Ильмаза Желика болон тус байгууллагын гишүүд болох 93 хүнийг баривчилсан байна.

Сүүлийн үед ХТ нь БНТУ-ын Европын холбоонд нэгдэх асуудлыг анхааралтай ажиглаж байгаа бөгөөд Туркийг Европын холбоонд нэгдсэнээр иргэншлийн, оюун санааны болон сүсэг бишрэлийн асар их хохирол амсах болно гэж ухуулдаг. Мөн ХТ нь БНТУ-ыг АНУ, Израйльтай хамтран ажилладаг гэж буруушаан, Турк улс лалын шашны тугийг мандуулж, нэгдсэн халифат байгуулах аяныг толгойлох ёстой гэж үздэг байна.

1970-аад онд ХТ нь Туркэд бүтэлгүйтсэнийхээ дараагаар Хойд Европт үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба одоо тус байгууллагын төв штаб нь ИБУИНВУ-ын нийслэл Лондон хотод оршдог. Лондон хотын ойролцоо орших олон тооны мусульман нийгэмлэгүүд нь тус байгууллагын үйл ажиллагаагаа явуулах үндэс, суурь болдог байна. Мөн ХТ-ын гишүүд Английн томоохон Их сургуулиудад оюутан элсүүлэх ажиллагааг идэвхтэй зохион явуулдаг ба шинээр гишүүн элсүүлэхдээ боловсролын түвшинг чухалчилж үздэг байна.

Английн тусгай албад тус байгууллагын үйл ажиллагаанд сүүлийн үед ихээхэн анхаарал хандуулах болсон ба ХТ-ын нийгэмд зүүлэх нөлөөллөөс эмээж, санаа зовинох болсон байна.

ХБНГУ нь 2003 оны 2 дугаар сарын 15-ны өдөр ХТ-ын үйл ажиллагааг “хүчирхийллийг сурталчилсан, хэт барууны үндэсний ардчилсан үзэлт бүлгүүдтэй сэжигтэй харилцаатай байсан” зэрэг үндэслэлээр Холбооны Улсын газар нутаг дээр үйл ажиллагаа явуулахыг нь хориглож дээрх арга хэмжээг авсан Өрнөдийн цорын ганц орон болсон юм.

ОХУ болон Төв Азийн ихэнх орнууд ХТ-ын үзэл суртлыг өөрийн орны аюулгүй байдалд заналхийлэл учруулна гэж үзэж

тус байгууллагыг террорист байгууллагын тоонд багтаадаг ба эдгээр орны тусгай албад нь ХТ-ын эсрэг идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. ОХУ-ын Холбооны Аюулгүй Байдлын Албаны дарга асан Николай Патрушев 2003 онд “ХТ нь ОХУ-ын газар нутаг дээр зэвсэгт бүлэглэл байгуулж цэрэг дайны ажиллагаа зохион байгуулдаг террорист бүлэглэл мөн” гэж мэдэгдэл хийж байсан ба ОХУ-ын Терроризмтэй Тэмцэх Үндэсний Зөвлөлийн мэдэгдлээс үзэхэд тус улсын ХАБА 2008 онд ХТ-ын 31 гишүүнийг баривчилж, шалгах ажиллагааг зохион байгуулжээ.¹⁴

ХТ нь Өмнөд Азид идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үйл ажиллагааны голомт нь Пакистан улс юм. ХТ нь 2000 оноос Пакистанд албан ёсоор үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба одоо тус улсын томоохон хотуудад орон нутгийн засаг захиргаа, батлан хамгаалахын нөлөө бүхий хүмүүсийн дунд ихээхэн дэмжлэг олж, олон гишүүдтэй болсон байна. Пакистаны цэргийнхэний дунд ХТ-ын үзэл суртал хүчтэй тархсан асуудалд тус улсын засаг захиргаа ихээхэн санаа зовдог. Мөн тус улсад ХТ-ын үйл ажиллагааг “Жамаат аль-Исламия”, “Севах-е сахаба” болон “Танзим-э ислами Пакистан” зэрэг экстремист бүлэглэлүүд дэмжиж ажилладаг байна.

Тус бүс нутаг дахь Индонез, Бали зэрэг мусульман шашинтай орнуудын удирдлага болон БНХАУ-ын засаг захиргаа нь ХТ-ын үйл ажиллагаанаас ихээхэн болгоомжилж байна.

Өрнөдийн судлаачдын үзэж байгаагаар “Хизб ут-Тахрир”-ын өнөөдрийн түвшинд хүрсэн хамгийн том амжилт нь мусульманчуудын сэтгэлгээний ертөнцөд өрнөж буй мэтгэлцээний чиг хандлагыг өөрчилж чадсан явдал юм. Усама бен Ладен болон Абу Мусаб аль Заркави зэрэг алан хядагчдыг лалын нэгдсэн халифат байгуулах асуудлаар үг хэлэх үед бид эдгээр хүмүүст нөлөөлсөн гэж бахархдаг. Мөн сүүлийн үед мусульманчуудын дунд өдөр ирэх тусам нэмэгдэж буй лалын шашинтны нэгдэл бий болгох үзэл санааны тулгуур үндэс нь “Хизб ут-Тахрир”-ын номлол болохыг онцлон авч үздэг байна.

Дүгнэлт

Дэлхий дахинд терроризмтай тэмцэх үйл ажиллагааны чухлыг ярьж, дэлхийн глобалчлалтай зэрэгцэн тэдний хийж байгаа тэмцэл хэрхэн глобалчлагдаж байгаа талаар ам уралдан ярьцгааж байна. Тэгвэл аливаа нэг дайсантай тэмцэхээс өмнө тухайн дайсныхаа талаар мэдээлэл цуглуулж, түүний мөн чанарыг

таньж мэдсэний эцэст дайтах арга, тактикаа боловсруулж хэрэгжүүлэх нь ялагчийн хууль байдаг билээ. Гэтэл өнөөдрийг хүртэл “терроризмтэй тэмцэх” асуудал нь хэлбэр, үр дүнгийн хувьд хэнтэй, юутай тэмцэж байгаагаа олж хараагүй, улс төрийн хүчирхийллийн зөвхөн хэлбэрт ач холбогдол өгч, энэ хүчирхийлэл хаанаас, ямар шалтгаанаар гарч байгааг тооцоолж чадалгүй явж ирсэн нь харагдаж байна. Түүгээр ч зогсохгүй энгийн номхон мусульманчуудыг гомдоох, тэдний уур бухимдал, өшөө хорсолыг төрүүлэх, радикализм, экстремизмд түлхсэн шинж чанартай үйл ажиллагааг явуулж иржээ. Энэ байдалд өрнөдийн судлаачид ч шүүмжлэлтэй ханддаг ба тэдний хийсэн судалгаанд АНУ болон тус улстай терроризмтэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллаж буй орнуудын нэр хүндийг лалын ертөнцөд унагаасан зарим фактуудыг онцлон авч үзсэн байдаг. Тухайлбал 1990-ээд оны эхэн үеэс эхэлж хурцдаж эхэлсэн Косовогийн асуудалд шуурхай арга хэмжээ авч чадалгүй, Европын төв хэсэгт олон мянган мусульманчуудыг хомроглон “хядах”-ыг хараад сууж байсан явдал, АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Буш 2001 оны 9 дүгээр сарын 11-ний үйл явдлын дараахан нэгэн хэвлэлийн бага хурал дээр “Энэ загалмайтны аян дайн, терроризмын эсрэг аян удаан хугацаагаар үргэлжлэх болно”¹⁵ гэж зарласан, Иракийн дайны үеэр АНУ-ын арми дайны үйл ажиллагаа явуулахдаа энгийн номхон иргэдийн орон сууц, “мечеть”¹⁶-үүдийг удаа дараа санаатай болон болгоомжгүй байдлаар бөмбөгдөж байсан, Абу Граиб, Гуантанамогийн нууц шоронд хоригдож байсан хүмүүстэй зүй бусаар харьцаж байсан явдал¹⁷ зэргийг дурьдаж болно.

Энэ бүхэн нь нэг талаар лалын шашныг экстремизм, радикализмтай хольж хутган, терроризмын эсрэг хийх аян дайныг “загалмайтны аян дайн” мэтээр ярьж, терроризмтай тэмцэгчдийн “имиж”, тэдэнд итгэх итгэлийг бууруулж, нийт лалын шашинтнуудын шашин, соёлд бүдүүлгээр халдсан болчимгүй явдал юм. Нөгөөтэйгүүр дээр дурьдсан фактууд нь “Хизб ут-Тахрир” зэрэг үзэл суртлын байгууллагуудад АНУ болон түүний холбоотнуудын үйл ажиллагааг лалын ертөнцийг хүчгүйдүүлж, нухчин дарах, колончлох замаар тэдний газрын гүн дэх баялгийг булаан авах зорилго бүхий “экспанс” шинжтэй үйл ажиллагаа мэтээр шүүмжлэх боломжийг олгож, өөрийн номлол, үзэл суртлыг идэвхтэй түгээн дэлгэрүүлэх, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх таатай нөхцөл болж иржээ. Тухайлбал Талибан хөдөлгөөн¹⁸ Афганистанд шариатын¹⁹ хууль дүрмийг сурталчилж, Өрнөдийн

соёлтой холбоотой бүхий л зүйлсийг хориглон, үзэл суртлаа дэлгэрүүлсээр Афганистаны хүн амын дунд олон дэмжигчтэй болж 1996 он гэхэд Кабул хотыг ямар нэгэн эсэргүүцэлгүйгээр эзлэн авсан. Түүний дараагаар Афганистаны Лалын Эмиратыг байгуулж Афганистан улсыг ОУ-ын террорист байгууллагуудыг санхүүжүүлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх бааз суурь болгон хувиргасан.²⁰

Ойрхи-Дорнод, Төв Азийн бүс нутгууд дахь нөхцөл байдал хүндэрч,²¹ ХТ-ын явуулж буй үйл ажиллагааны цар хүрээ болон дэлхийн лалын шашинт хүн амын эрчимтэй өсөлт, тэдний сэтгэлгээнд гарч буй өөрчлөлт маш хурдацтайгаар явагдаж байна. ХТ-ын дэлгэрүүлж буй үзэл суртлын үр дүнд лалын нэгдсэн халифат гэгч бий болвол ямар хор уршиг учрах нь тодорхой бөгөөд нэгэнтээ Харвардын Их сургуулийн доктор Самуэль Хантингтоны дэвшүүлсэн онол “Иргэншил хоорондын мөргөлдөөн”-нд хүргэхийг ч үгүйсгэх арга үгүй юм.

“Өрнөдийн орнууд ХБНГУ-ын нэгэн адил лалын радикал үзэл суртлыг номлогч байгууллагуудын үйл ажиллагаанд анхаарал хандуулж, холбогдох арга хэмжээг авах, ХТ-ын үйл ажиллагааг хориглосон Арабын ихэнх орнууд, ОХУ болон Төв Азийн орнуудтай энэ чиглэлд туршлага солилцож, хамтран ажиллах, ХТ-ын номлол, үзэл суртлын эсрэг тэмцэх шинэ стратегийг дэлхийн улс орнууд хамтран боловсруулах шаардлагатай байгааг өрнөдийн судлаачид онцлон үзэж байна.

Энэхүү шинэ стратегийн үндэс нь уламжлалт лалын шашны энх тайванч, энэрэнгүй үзэл, исламын либералчлал байх ёстой ба лалын ертөнцөд нөхцөл байдлыг хурцатгаж, гомдол, хорсолыг төрүүлсээр буй АНУ-ын Ойрхи Дорнод дахь буруу бодлогын илрэл болох Израйль-Палестины асуудалд дахин үнэлэлт дүгнэлт өгсөн, Европын орнуудад амьдран сууж буй мусульманчуудыг либералчлах ажиллагааг идэвхжүүлсэн, ХТ зэрэг лалын радикал үзэл суртлыг номлогч байгууллагуудын үнэн бодит дүр төрхийг олон улсын хэмжээнд ил болгоход чиглэсэн шинжтэй байх шаардлагатай гэж үзэж байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Витторио Форментигийн “Annuario Pontifico” лавлах. Мөн <http://www.news.ru.com/arch/religy/29jul2008/moslems.html>.
2. Лалын шашин - Эртнээс Монголчууд ислам шашныг “Лалын буюу Муххамедын” шашин гэж нэрлэж иржээ.
3. “Радикализм” /латин хэлний- radix-үндэс гэсэн үгнээс гаралтай/ нь улс төр, нийгмийн үзэл суртлаа хэрэгжүүлэхийн тулд ямар нэгэн буулт хийлгүйгээр оршин байгаа тогтолцоог эрс шинэчлэх үзэл. <http://ru.wikipedia.org/wiki/>, <http://saint-juste.narod.ru/radicalism.htm>
4. Политическая радикализация ислама 2004 г. Зейно Баран
5. “Хизб ут-Тахрир” /буюу “Чөлөөлөх Нам”, цаашид “ХТ” гэх/ нь ислам шашны, радикал суннитын сүүлийн үеийн /”авангард” гэж хэлж болох/ урсгал юм.
6. “Джорж Маршаллын Аюулгүй байдлын сургалтын төв” №3259-р сургалтын материал
7. “Аль Каида” /үндэс, бааз, фундамент гэсэн араб үг/ нь лалын фаххабист урсгалыг баримтлагч олон улсын №1 террорист байгууллага. 1980-аад оны дундуур ЗХУ-ын цэрэгтэй тэмцэхээр Афганистанд байгуулагдсан ба үндсэн зорилго нь “Исламын нэгдсэн халифат” байгуулах явдал. 1998 онд Кенни, Танзани, 2000 онд Йемен, 2001 онд АНУ, 2005 онд ИБУИНВУ-д тус тус томоохон террорист ажиллагаа зохион байгуулсан. <http://studies.agentura.ru/tr/alqaeda/>
8. “Хезболла” /Аллахын нам гэсэн араб үг/ нь 1982 онд Ливанд байгуулагдсан. Ливан дахь аливаа колончлогчдыг хөөн зайлуулах, урвагчдыг шийтгэх, Ливанд лалын журамт улсыг байгуулах зорилготой. Иран, Сири улсуудаас цэрэг, санхүүгийн тусламж авдаг. Австрали, ИБУИНВУ, Канад, Нидерланд, Израйль, АНУ зэрэг орнуудын террорист байгууллагын жагсаалтанд багтдаг. Жич: Зарим тохиолдолд “Хезболлах” гэж нэрлэдэг нь Перс хэлний онцлогоос улбаатай. <http://almashriq.hiof.no/lebanon/300/320/324/324.2/hizballah/>, <http://Ghaliboun.net>
9. “Хамас” бүлэглэлийг “Мусульман ахан дүүс” байгууллагын радикал үзэлтнүүд 1987 онд Газын зурваст байгуулсан. Зорилго нь Палестины бие даасан лалын журамт улс байгуулах явдал байсан ч, 1984 онд Израйль улс байгуулагдсанаар зорилгоо өөрчилсөн. “Хамас” бүлэглэл нь Канад, ЕХ, Израйль, Япон, АНУ, Иордани, Австарли,

- ИБУИИНВУ зэрэг орнуудад террорист байгууллагад тооцогддог. <http://www.religio.ru/dosje/21/80.html>
10. “Ваххабизм” нь 13 дугаар зуунд үүссэн лалын шашны урсгал бөгөөд энэ урсгалыг баримтлагчид лалын шашин нь зөвхөн гэгээн зөнч Муххамед болон түүнийг дагалдагч гурван үеийн номлолд тулгуурлах ёстой гэж үздэг байна. www.islam.ru/lib/warning/sekty/vahabizm/
 11. “Фундаментализм” нь шашны хуучинсаг үзлийг баримтлагч урсгалуудын ерөнхий томъёолол бөгөөд үзэл суртлын үндэс нь гэгээн судруудад тэмдэглэгдсэн зан үйлийг ягштал мөрдөж, тухайн шашинд чиглэсэн аливаа төрлийн шүүмж, либерал хэлбэрийн тайлбарыг үгүйсгэх явдал. Фундаменталист урсгалууд нь лалын шашинд төдийгүй христийн шашинд ч идэвхтэй байр суурь эзэлдэг. http://www.krugosvet.ru/enc/istoriya/FUNDAMENTALIZM_V_ISLAME.html
 12. “Гэгээн элч Муххамед” нь эхний ээлжинд маш хүлээцтэй байж өөрийн үзэл санаагаа түгээн дэлгэрүүлсэн ба түүний дараагаар өөрийн үзлийг баримтлагч бүлгийг зохион байгуулж төрийн эргэлт хийснээр зорилгодоо хүрсэн байдаг.
 13. “Политическая радикализация ислама” 2004 он. Зейно Баран
 14. <http://ru.wikipedia.org/wiki/>
 15. Peter Ford, “Europe Cringes at Bush’s Crusade Against Terrorism”, Christian Science Monitor, Sep 19, 2001
 16. “Мечеть” /казах хэлэнд –мешит/-лалын шашны сүм, хийд.
 17. Политическая радикализация ислама 2004 г. Зейно Баран
 18. “Талибан хөдөлгөөн” 1994 онд Гуштун үндэстнүүдийн дунд үүсч 1996-2001 онд Афганистан улсад төрийн эрх барьж байсан. 2004 онд Пакистаны хойд хэсэгт Вазиристан улсыг байгуулсан. Тус улсын тусгаар тогтнолыг Арабын Нэгдсэн Эмирт Улс, Пакистан, Саудын Аравид хүлээн зөвшөөрсөн байна.
 19. Шариат /араб хэлэнд (зөв) зам, хэлбэр, эх сурвалж гэсэн утгатай/ нь лалын шашны эрх зүй, ёс зүй болон сүсэг бишрэлийн хэм, хэмжээ бөгөөд өөртөө Үндсэн хуулийн, Иргэний, Эрүүгийн, Захиргааны, Гэр бүлийн, Процессийн эрх зүйн хэм хэмжээг өөртөө агуулдаг.
 20. <http://ru.wikipedia.org/wiki/>
 21. АНУ-ын засаг захиргаанаас Төв Азийн бүс нутагт нөхцөл байдал хүндэрч байна гэж үзэж Афганистанд нэмэлт цэрэг илгээх асуудлыг авч хэлэлцэж байна.